

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САМБУУНЯМ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИГДСАН ЗАРИМ БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ
ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар УАГ-АД/2025-06

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО: “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим барилгын ажлын зураг төсөл, болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Эхлэх хугацаа: 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр

Дуусах хугацаа: 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

Байршил: Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан хавсралтад заасан зарим барилга, байгууламж.

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолд үндэслэн хийх “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитад Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу мэргэжлийн тусгай мэдлэг, үр чадвар бүхий этгээдийг шинжээчээр татан оролцуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажилбаруудыг гүйцэтгэнэ. Үүнд:

Зорилго	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим барилга, байгууламжийн зураг төслийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандарт шаардлагад нийцэж, үр дүн, үр нэлөө бий болсон эсэхэд дүгнэлт гаргахад оршино.		
д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Шалгуур үзүүлэлт

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Шалгуур үзүүлэлт
1	Барилга, байгууламжийн зураг нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах;	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйл “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх”, 38 дугаар зүйл “Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг”, 39 дүгээр зүйл. “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”, холбогдох бусад норм, дүрэм, стандарт	<ul style="list-style-type: none"> ✓ Техникийн нөхцөл, бусад зөвшөөрлийг хууль журмын хүрээнд авсан байх; ✓ Зураг төслийг холбогдо тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, хуулийн этгээд боловсруулсан байх; ✓ Зурагт магадлал хийж, дүгнэлт гаргасан байх; ✓ ТЭЗҮ, ажлын зураг, бусад баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан байх; ✓ Суурилагдах тоног төхөөрөмж, тоноглолтын ашиглалтын зардлыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар сонгосон байх;
2	Барилга, байгууламжийн төсвийг батлагдсан зургийг үндэслэн, холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон эсэхэд дүгнэлт гаргах;	Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйл “Барилга байгууламжид тавих шаардлага”, 24 дүгээр зүйл “Барилга байгууламжийн төсөв”, 25 дугаар зүйл “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх”, 39 дүгээр зүйл “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт”, “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/, “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12*/2020/	<ul style="list-style-type: none"> ✓ Магадлал хийгдсэн зургийг үндэслэсэн байх, ✓ Төсвийг хүчин төгөлдөр мөрдэж байгаа хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон байх, ✓ Байгууламжид ашиглах материал, тоног төхөөрөмжийн үнийг үндэслэл судалгаатай тооцож оруулсан байх; ✓ Төсөвт магадлал хийж, дүгнэлт гаргасан байх;

3	<p>Барилга байгууламжийн ажил нь магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах;</p>	<p>Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйл "Барилга байгууламжид тавих шаардлага" 37 дугаар зүйл "Захиалагчийн чиг үүрэг" 38 дугаар зүйл "Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг", 40 дүгээр зүйл "Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг", Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3 дугаар зүйл "Захиалагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа", холбогдох бусад норм, дүрэм, стандарт</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байх; ✓ Тоног төхөөрөмж, тоноглол угсралтын ажлыг холбогдох норм дүрмийн дагуу угсарсан, шалгасан байх; ✓ Бусад инженерийн шугам сүлжээ, дагалдах ажлуудыг зураг төслийн дагуу иж бүрэн гүйцэтгэсэн байх; ✓ Туршилт тохируулгыг хийж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байх; ✓ Ажлын үр дүн, үзүүлэлтээр гэрээг дүгнэж баталгаажуулсан байх;
4	<p>Барилга угсралтын ажилд гүйцэтгэгчийн дотоод хяналт болон захиалагч, зохиогч, техникийн хяналт хийсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах;</p>	<p>Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйл. "Захиалагчийн чиг үүрэг", 38 дугаар зүйл. "Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг", 40 дүгээр зүйл. "Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг", 42 дугаар зүйл "Зөвлөх үйлчилгээ", 47 дугаар зүйл. "Барилга байгууламжийн техникийн улсын хяналт", "Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм", Барилга, хот байгуулалтын Сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"; холбогдох бусад хууль, журам, норм, дүрэм, стандарт</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Барилга байгууламжийн ажилд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагатай захиалагч, зохиогчийн хяналтын эсвэл зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байх; ✓ Гүйцэтгэгчийн дотоод хяналтыг өдөр тутам гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгасан байх; ✓ Эрх бүхий байгууллагаас барилга байгууламжийн ажилд үе шатны болон өдөр тутмын хяналт гүйцэтгэсэн байх; ✓ Ил, далд ажлын актыг үнэн зөв, бүрэн баталгаажуулсан байх; ✓ Бүх төрлийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байх;
5	<p>Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан байдалд дүгнэлт гаргах;</p>	<p>Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл "Барилга байгууламж ашиглалтад оруулах", Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм", Засгийн газрын 2021 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, холбогдох</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комиссыг хууль, журмын дагуу томилж ажиллуулсан байх; ✓ Ашиглалтад хүлээн авах ажлын хэсэг хууль, журмын дагуу ажилласан байх; ✓ Ажлын хэсгийн гишүүдээс өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн байх;

		бусад хууль, журам, норм, дүрэм, стандарт	<ul style="list-style-type: none"> ✓ Барилга, байгууламжийн баримт бичгийг архивын нэгж болгон, архив, ашиглагч байгууллагад хүлээлгэж өгсөн байх; ✓ Барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг журмын дагуу бүртгэж, паспортжуулсан байх;
6	Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад барилгын материалын орц, too хэмжээ, нэр төрөл, чанарыг хянаж, батлагдсан төсөв болон бодит гүйцэтгэлийн хооронд too хэмжээ, чанарын зэрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг too хэмжээ болон үнийн дүнгээр гаргах;	Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйл "Барилга байгууламжийн төсөв", "Барилгын унэ бүрдлийн үндсэн дүрэм /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12*/2020/, холбогдох бусад хууль, журам, заавар, норм, дүрэм.	<ul style="list-style-type: none"> ✓ Барилга, байгууламжид ашигласан барилгын материалын орц, too хэмжээ, нэр төрөл, чанар нь зураг төсөл, холбогдох норм, дүрэм, стандартад нийцэж байх. ✓ Олгосон санхүүжилт нь гүйцэтгэсэн ажлын too хэмжээ, төсөвт өртөгтэй нийцэж байх. ✓ Магадалшгүй ажлын зардал, бусад зардалд хэтрэлт, хэмнэлт гарсныг гүйцэтгэлийн санхүүжилтэд бүрэн, үнэн зөв тусгасан байх;

Гэрээт ажилд тавигдах шаардлага, хэмжээ, формат:

- Шинжээчийн ажлын тайлан нь 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зайд "single" үсгийн хэмжээ Arial 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, төсвийн тооцооллыг эрх бүхий төсвийн программаар гүйцэтгэсэн хавсралтуудтай байна.
- Шинжээчийн дүгнэлт гаргах үндэслэл болгосон холбогдох нотлох баримт, тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль, стандарт, норм, дүрэм зэрэг шалгуур болгосон мэдээллийн эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.
- Тооцоолол, дүгнэлт гаргахад ашигласан хууль, стандарт, норм дүрэм, шалгуур болгосон мэдээллийн эх үүсвэрийг тодорхой тусгасан байна.

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, тус ажлын даалгаврын хавсралтад заасан барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөл, ажлын гүйцэтгэлд хоёрдугаар бүлэгт заасан гүйцэтгэх ажил, үүргийн дагуу дүгнэлт гаргах ажлыг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажилбаруудыг төсөл, арга хэмжээ бүрээр, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, барилга, байгууламжийн зураг, төсөв, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртгийн нэмэлт нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартын шаардлагуудтай нийцсэн эсэхийг хянаж, гарсан үр дүнг тусгасан мэргэжлийн дүгнэлт бүхий тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн ажил гүйцэтгэх явцад авто зам, замын байгууламжийн зураг төсөв, гүйцэтгэлд илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтээс гадна илэрсэн зөрчлийг арилгах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх боломжийн талаар зөвлөмж, санал боловсруулж, тайландаа тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох баримт, материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

ТАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд ажиллах баг, хуулийн этгээд нь /цаашид “шинжээч” гэх/ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, тус ажлын даалгаврын хавсралтад заасан барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөл, ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргахад шинжээчид тавигдах шаардлагын дагуу багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Тус ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэхээр шалгарсан шинжээч нь захиалагч Үндэсний аудитын газрыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, аудитын багтай уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллах болно.

Үе шатны ажлын явцад бий болсон шийдвэрлэх боломжгүй асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, хамтарч ажиллана.

ЗУРГАА. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь тухайн аудитад оролцох ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээч нь баг, хуулийн этгээд байж болно. Тавигдах шаардлагын хүрээнд ажиллахад дараах боловсролын үндсэн мэргэжил, зэрэг, мэргэшлийн шаардлага тавина.

Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Дүгнэлт гаргахаар санал ирүүлсэн барилга байгууламжийн чиглэлээр зураг төсөл боловсруулах эсвэл зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байх
Ажиллах хүчиний шаардлага:
- Үндсэн ажилтны бүрэлдэхүүнд барилга угсралтын зөвлөх инженер, мэргэшсэн инженер, тэргүүлэх төсөвчин байна.

Багийн хувьд:

- Багийн ахлагч нь барилга угсралтын зөвлөх зэрэгтэй инженер, барилга, байгууламжийн зураг төсөл, магадлалын чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, барилга угсралтын ажлын гүйцэтгэл, төсөвт өртөгт мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргаж чадахуйц, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага туршлагатай байна.
- Багийн гишүүдэд тэргүүлэх төсөвчин, мэргэшсэн инженер байна.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж шаардлагатай судалгаа шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн албан бичиг, хүсэлт, анкет, аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө, танилцуулга), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);
- Энэхүү ажлын даалгаварт заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлнэ.

Шинжээч нь аудитын явцад олж авсан төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцтالыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.


Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Хянасан:

ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХБОЛД

Ю.ЭНХТУЯА

Боловсруулсан:

АУДИТОР



Б.ИДЭРБАЛЖИНЯМ

Б.ИДЭРБАЛЖИНЯМ

2025 оны 02 сарын 24-ны өдөр баталсан
УДАГ-АО/2025-06 дугаар тажлын даалгаврын хавсралт

Шинжээчийн дүгнэлт гаргах
барилга байгууламжийн ажлын жагсаалт

/Багц 1/

№	Төсвийн өрөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг /сая төгрөг/
			эхлэх	дуусах	
1	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Өвөрхангай, Бат-Өлзий/	2022	2025	9,538.5
2	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/ Сайр	2022	2025	26,964.8
3	БОЛОВСРОЛЫН САЙД	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Цахир сум/	2019	2024	7,082.6
4	БОЛОВСРОЛЫН САЙД	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 op /Архангай, Тариат сум/	2019	2024	1,120.3

2025 оны 2 сарын 24-ны өдөр баталсан
УДТ-АД/2025-06 дулаар ажлын даалгаврын хавсралт

Шинжээчийн дүгнэлт гаргах
барилга байгууламжийн ажлын жагсаалт

/Багц 2/

№	Төсвийн өрөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг /сая төгрөг/
			Эхлэх	Дуусах	
1	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	Орон сууцжуулах төслийн дэд бүтэц /Баянхонгор, Баацагаан сум/	2022	2025	9,663.9
2	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛГҮЙ САЙД	Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/	2022	2024	4,995.0
3	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/	2022	2025	10,990.1
4	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/	2021	2025	15,284.4